# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Н.САНДУЙСҮРЭНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 1 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.1.26.Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бусад төрийн байгууллагатай шаардлагатай мэдээлэл солилцох сервис хөгжүүлэлт хийнэ. | Бусад төрийн байгууллагатай шаардлагатай мэдээлэл солилцох сервис хөгжүүлэлт хийх ажлын хүрээнд:<br>• **Шуудан илгээмжийн задаргааны мэдээллийг КАИС системд илгээх сервес**<br>- Upost системийг цаашид ашиглах боломжгүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор шуудангийн тусгай зөвшөөрөлтэй Аж ахуйн нэгжүүдээс өөрийн ашиглаж буй мэдээллийн системийг Гаалийн байгууллагын мэдээллийн системтэй шууд холбох технологийн шийдлийг гаргаж өгөхийг илэрхийлсэн. Тус хүсэлтийн дагуу агаарын болон газрын шуудан илгээмжийн задаргааны мэдээллийг гаалийн байгууллагын мэдээллийн системд цахимаар илгээх буюу ААН-ийн мэдээллийн системээс гаргах сервес хөгжүүлэлт, гарын авлагыг боловсруулж, ХБГ, УХШИГГ-т хүргүүлсэн.<br>• Гаалийн мэдээллийн систем, **Зам тээврийн салбарын** нэгдсэн платформ хооронд өгөгдөл дамжуулах, солилцох сервисийг гарган өгсөн.<br>• **Хилийн боомтын захиргааны** үйл ажиллагаанд шаардлагатай "Гадаад худалдааны гүйцэтгэл орон, бараа, боомтоор", "Гол нэрийн барааны динамик статистик мэдээлэл", "Эрдэс бүтээгдэхүүний импорт, экспортын мэдээлэл" -ийн сервесийг Гаалийн байгууллагын мэдээллийн системээс гарган өгсөн. | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • ХХААХҮЯ-с олгож буй архи, согтууруулах ундааны импортын зөвшөөрлийг гаалийн мэдүүлэгт татах сервис хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн.<br>• **УБТЗ мэдээлэл солилцоо:**<br>- УБТЗ-тай хамтран улсын хилээр гарч буй вагон цувааны мэдээллийн ГУАБ-ын тоон гарын үсгийн дугаарын хамт баталгаажуулалт хийж УБТЗ-руу цахимаар илгээх туршилт 10-р сард туршилт хийгдэж 12 сард нэвтрүүлэхээр болсон.<br>- Төмөр замаар тээвэр хийгдэх экспортын гаалийн бүрдүүлэлт хийх үед УБТЗ-д хүсэлт өгсөн захиалгын дугаарыг экспортын гаалийн мэдүүлэгт цахимаар татаж мэдүүлэг "Гаалийн хяналтанд байгаа" төлөвт УБТЗ-руу зөвшөөрлийн мэдээллийг илгээх туршилт хийгдэж амжилттай болсон. Тухайн хүсэлт УБТЗ-д баталгаажуулалт хийгдсэн үед КАИС системрүү илгээх мэдээлэл УБТЗ-д хийгдэж байгаа тул туршилт хийж амжилттай болсон үед нэвтрүүлэхээр хүлээгдэж байна. | | |
| **Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх** | | | | | | | |
| 2 | Мэдээллийн нэгдсэн санд дүн шинжилгээ хийж, өгөгдлийг боловсруулсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн (RIBS) хүрээнд хийгдсэн гаалийн мэдээллийн системийн шинэчлэлийг бүрэн нэвтрүүлэх, баталгаат засварын хугацаанд сайжруулалт хийхэд гүйцэтгэгч компанитай хамтран ажиллана. Гаалийн мэдээллийн системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, нэвтрүүлэлтийг жигдрүүлсэн байна. | 1. Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн (RIBS) хүрээнд хийгдсэн гаалийн мэдээллийн системийн шинэчлэлийг бүрэн нэвтрүүлэх, баталгаат засварын хугацаанд сайжруулалт хийхэд гүйцэтгэгч компанитай хамтран ажиллах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>1) Бүрдүүлэлтийн дараах шалгалтын системийн бизнес процессд дараах нэмэлт сайжруулалтыг хийсэн.<br>- Бүрдүүлэлтийн дараах шалгалтад томилогдон ажиллах ГУАБ, ГУБ нарын шалгалтын хуваарийг автоматаар хийх, маягтуудыг PDF хэлбэрээр харах боломжтой болсон.<br>- БДШГ-аас ирүүлсэн журмын дагуу програмд засвар өөрчлөлтийг хийсэн.<br>- ААН-ийг шалгах хүсэлтийг ЭУХ-ээс БДШГ-луу хүсэлт илгээх боломжийг бүрдүүлсэн.<br>- Тайлан боловсруулах (дашбоард) хэсэгт нэмэлт хөгжүүлтийг хийсэн.<br>- Нэхэмжлэлийг ААН-ээр ГУБ үүсгэж, гааль.мн системээс ААН харах боломжтой болсон.<br>- Симс системд ГУБ үр дүнгийн мэдээллийг бүртгээд КАИС системрүү илгээх<br>- Симс системд ААН-ийн зөрчлийн мэдээллийг татах | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2) Тээврийн хэрэгслийн бүртгэлд нэмэлт өөрчлөлт хийх ажлын хүрээнд дараах ажлыг нэмэлт хөгжүүлэлтийг хийсэн.<br>- Хил дээрх машины хүсэлт дээр барааны мэдээлэл бүртгэх<br>- Ханги дахь гаалийн газар, Дорнод аймаг дахь гаалийн газар, Бичигт гаалийн газруудад тээврийн бүртгэл автоматаар үүсгэх тохиргоо өөрчлөлт<br>- ЗҮГГ-ын нүүрсний бүрдүүлэлтэд тээврийн бүртгэл автоматаар үүсгэх тохиргоо өөрчлөлт<br>3) Манифестын нэмэлт өөрчлөлт<br>- Дотоодын дамжин өнгөрөх манифестыг бусад байгууллагаас мэдээлэл холбох API функцийн хөгжүүлэлт<br>- Дотоодын дамжин өнгөрөх манифестыг бусад байгууллагаас мэдээлэл татаж мэдээллийг нөхөн бөглөх процессыг хялбаршуулсан.<br>4) Экспортын мэдүүлгийн нэмэлт хөгжүүлэлт<br>- Төмөр замын захиалгын хуудас мэдүүлгийн системд холбох хөгжүүлэлт<br>- Улсын төсөвт үйлдвэрийн газрын тээврийн гэрээний сервис холбох хөгжүүлэлт хийгдсэн.<br>- Мэдүүлэг дээрх дотоодын дамжин өнгөрөх манифест холбох хөгжүүлэлт<br>5) Хяналтын бүсийн үлдэгдлийн модуль дээр Улсын төсөвт үйлдвэрийн газрын тээврийн гэрээний сервис холбох хөгжүүлэлт | | |
| 3 | Программ хангамжуудыг шинээр боловсруулах, хөгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд:<br>1.Захиргаа дотоод ажлын системийн нэмэлт хөгжүүлэлт болон засвар өөрчлөлтүүдийг ЗББНДБ-ын дотоод зурвасын дагуу хийж гүйцэтгэнэ.<br>2.Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийн шинэчлэх, сайжруулах хөгжүүлэлтийг ЗББНДБ-ын дотоод | 1. Захиргаа дотоод ажлын системийн нэмэлт хөгжүүлэлт болон засвар өөрчлөлт<br>• ЧХОУНБГГ-ын цаг бүртгэлийн төхөөрөмжийг ЗДАС -д холбосон. Ингэснээр ЗДАС системийн цаг бүртгэлээр ЧХОУНБГГ-ын цаг бүртгэлийг хянах боломжтой болсон.<br>2. Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийн шинэчлэх, сайжруулах хөгжүүлэлт<br>• Хойшлуулсан албан татварын програм<br>- Гаалийн мэдүүлгийг ТЕГ-н цахим системд илгээж, ААН-үүд НӨАТ-н тайланд гаалийн мэдүүлгээр төлсөн НӨАТ-н тооцуулж боддог. Гэвч гаалийн бүрдүүлэлтэд хойшлуулсан татвар төлөлттэй мэдүүлгүүд нь НӨАТ-г гаалийн байгууллагад төлөөгүй үедээ ТЕГ-н системд НӨАТ-г тооцуулах эрсдэл үүсэж байсан. Иймээс татвар хойшлуулах төлөлтийн код (401, 402, 501, 502, 503, 504) бүхий гаалийн мэдүүлгийг ТЕГ-ын цахим төлбөрийн | 01.01-11.30 | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td>зурвасын дагуу хийж гүйцэтгэнэ.<br><br>Сүүлийн хагас жилд:<br>1.Захиргаа дотоод ажлын системийн нэмэлт хөгжүүлэлт болон засвар өөрчлөлтүүдийг ЗББНДБ-ын дотоод зурвасын дагуу хийж гүйцэтгэнэ;<br>2.Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийн шинэчлэх, сайжруулах хөгжүүлэлтийг ЗББНДБ-ын дотоод зурвасын дагуу хийж гүйцэтгэнэ.<br>3.Гаалийн баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, гаалийн хяналтын бүс тогтоолгох, тээвэрлэгч байгууллагад олгодог гаалийн итгэмжлэл авах, түр агуулах ажиллуулах хүсэлтийг хүлээн авч, хянаж, шийдвэрлэх license.mn-д хөгжүүлэлт хийлгэх саналыг ГТСМТТ УҮГ-т хүргүүлнэ.<br>4.Татваргүй барааны дэлгүүрийн программыг бүрэн нэвтрүүлж, горимын</td><td>баримтын системрүү мэдүүлэг зөвшөөрөгдсөн үед явуулдаг байсныг болиулж, татвар орлогын газраас хойшлогдсон татвар төлөгдсөн үед тухайн мэдүүлгийг илгээдэг болгож хөгжүүлэлтийг хийн 2024 оны 10-р сарын 01-ний өдрөөс КАИС системд нэвтрүүлсэн. Мөн тус газрын хүсэлтээр төлөлтийн код 402 буюу засгийн газрын шийдвэрээр хэсэгчлэн төлөгдсөн автобензин дизель түлшний мэдүүлгийн татварын үлдэгдэл төлөгдөж үлдэгдэлгүй болсон үед КАИС системээс автоматаар ТЕГ- ын цахим төлбөрийн баримтын системрүү илгээх хөгжүүлэлтийг хийж 2024 оны 12-р сарын 01-ний өдрөөс нэвтрүүлсэн.<br>• Нүүр хуудас (Эрсдлийн удирдлага) > Зорчигч онилох Модуль > Гадаад жуулчны эрсдэлтэй барааны мэдээлэл цэсэнд “Санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ”-аас гаргаж өгсөн сервисын мэдээллийг авч МУ-аас гарч буй гадаад жуулчдын НӨАТ-ын буцаан олголтын талаарх барааны мэдээллийг дуудан авч хянан, шалгах боломжоор хангасан. ХШ ГУБ болон ХШГУАБ-ын эрх бүхий албан тушаалтан тухайн цэсэнд мэдээллийг харах болон татан авч үр дүнгээ оруулан илгээх боломжоор хангасан.<br>• УХШИГГ-ын хяналтын бүсэд орж буй газрын ачаанд бичигдсэн манифестын мэдээллийн тээврийн баримтыг ашиглан “UPOST” системд оруулсан задаргааг тухайн хяналтын бүсийн ХШ ГУБ татан оруулдаг. Үүнтэй холбоотойгоор тухайн манифестад хавсаргасан тээврийн баримтын урт 12 тэмдэгт байх шаардлагатай байдаг ба МТГ-луу холбогдож солиулдаг байсныг тухайн ГХБ-д ажиллаж буй ХШ ГУАБ тээврийн баримтын тухайн өдрийнхөөр системээс автоматаар солих боломжийг бүрдүүлсэн.<br>• КАИС системд ашиглагдаж буй гадаад худалдаанд оролцогч ААН-ийн мэдээлэлд “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуй нэгж”-ийн мэдээллийг оруулах боломжоор хангасан.<br>• Татварын ерөнхий газрын системд тээвэрлэгч ААН тээврийн гэрээг оруулан бүртгэж гаалийн мэдүүлэгт хавсаргасан тохиолдолд тухайн тээврийн гэрээний мэдээллийг “Санхүүгийн мэдээллийн технологийн төв УҮГ”-аас гаргаж өгсөн сервисийн дагуу хянан шалгах боломжоор КАИС системд өөрчлөлтийг оруулж нэвтрүүлсэн.</td><td></td><td></td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td>хэрэгжилтийг сайжруулна.<br>5.Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа дэлгүүрүүдэд тавих хяналтыг сайжруулах программыг нэвтрүүлнэ.</td><td>• Эхлэл (Бүрдүүлэлт) > Гаалийн бүрдүүлэлт > Экспортын мэдүүлэг > Хилийн биет шалгалт цэсэнд “Илгээх үеийн тээврийн хэрэгслийн дугаар” хайлтыг хүснэгтэд нэмж өөрчлөлтийг оруулсан.<br>• СДШХ-ээс ирүүлсэн дотоод зурвасын дагуу өдөр бүрийн мэдээг гарган Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам болон удирдлагуудад хүргүүлж ажилладаг. Уг мэдээг бямба, ням гаригуудад гаргахаа больсон боловч амралтын өдрүүдийн мэдээг нөхөж өгөх шаардлага тавигдаж байна.Иймд өдөр бүрийн мэдээ гаргадаг КАИС системийн тайлан цэсний “Импорт, экспортын зарим барааны мэдээ ” болон “Экспортын статистик мэдээлэл” тайлангуудад он,сар,өдөр сонгодог өөрчлөлтийг хийж өгнө үү гэсний дагуу өөрчлөлтийг хийж гүйцэтгэсэн.<br>• Статистик, дүн шинжилгээний хэлтсээс ирүүлсэн Импорт, экспортын зарим мэдээ цэсэнд Эксел файлруу хөрвүүлэхэд огнооны дагуу өссөн дүнгээр гарахгүй байсанг хайлтын огноогоор хайж гаргах боломжтой болгож засварлаж системд мэдээллийг татан авах боломжоор хангасан.<br>• Барааны ангилал, үнэлгээний хэлтсээс КАИС программ дахь гаалийн бүрдүүлэлт дэд цэсний үнийн мэдээллийн сан доторх хэлцлийн үнийн бааз дахь жагсаалтыг эксел-рүү гаргадаг болгох, бүртгэсэн губ болон хугацааг гаргадаг болгох програмын даалгавар ирүүлсэний дагуу засвар өөрчлөлтийг хийж, тус хэлтэст хүлээлгэн өгсөн.<br>• "Засгийн газрын шийдвэрээр хойшлогдсон(401) болон хэсэгчлэн төлөгдсөн(402) төлөлтийн код бүхий импортын мэдүүлгийг ТЕГ ТУНС систем рүү татвар төлөгдөөгүй мэдээллийг илгээж, татварын төлсөний дараа төлсөн мэдээллийг илгээдэг болгож хөгжүүлэлт хийсэн.<br>• Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасан татвараас чөлөөлөгдөх барааны хяналтыг сайжруулахтай холбоотойгоор 401, 402, 403, 507, 507-1, 623 горимын кодыг сонгож мэдүүлсэн бүрдүүлэлтийг бусад горимын кодоор мэдүүлсэн барааны бүрдүүлэлтээс салгаж, томилогдсон гаалийн улсын байцаагчид хуваарилах боломжийг бүрдүүлж програмд засвар өөрчлөлтийг хийсэн.</td><td></td><td></td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>• Мэдүүлгийн явцын тайлан бичиг баримтын шалгалт хийхээс өмнөх ББГУБ-ын дугаарыг харуулахгүй байдлаар хөгжүүлсэн.<br>• Хялбаршуулсан журам програмаас экселрүү гаргах үед дэлгэрэнгүй болон хураангүй байдлаар гаргах боломжтой болсон.<br>• Барааны ангиллын шийдвэрийн сангийн Гомдол шийдвэрийн сан хэсэгт нэмэлт хөгжүүлэлт хийж бараа ангиллын кодыг ерөнхий газар болон шийдвэр анх үүсгэх маргаантай ангиллын гэсэн 2 төрөлтэйгээр оруулах боломжтой болгох мөн тухайн оруулсан гомдолыг үүсгэсэн ГУБ, ГУАБ л засах боломжтой болгон шинэчилсэн. Мөн гомдол мэдээлэл оруулахад үндсэн мэдээлэл, ГЕГ дүгнэлт, шүүхийн шийдвэрийн дүгнэлт гэсэн хэсгүүдтэй болгож нэмэлт хөгжүүлэлтийг хийсэн.<br>• ААН Төрөл, Лиценз цэсний Чөлөөлөлтийн кодын бүртгэлийн хуудас холбоотой мэдүүлгийн жагсаалтыг харуулах боломжтой болгож, бүртгэлийн хуудсыг pdf хэлбэрээр тайлан болгон татаж авах боломжтой болгосон. Мөн бүртгэлийн жагсаалт програмд бүртгэлийн жагсаалтыг excel татаж авах хөгжүүлэлтийг хийсэн.<br>• Пүүний програмд орохын бүртгэл хийгдсэн тээврийн хэрэгслийн чиргүүлийн жин харагддаггүй бөгөөд зөвхөн толгойн өөрийн жин нь харагддаг. Энэ нь пүүний ГУБ тухайн тээврийн хэрэгслийн чиргүүлийн жин зөв татагдаж байгаад хяналт тавихад хүндрэлтэй байдаг учир ЗҮГГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу засвар өөрчлөлтийг хийсэн.<br>• Тээвэр зууч нар Чингэлэг хяналтын програмд чингэлгийг шинээр бүртгэхдээ ТАР-ын жинг оруулдаг болгох, ТАР-ын жин буруу оруулсан тохиолдолд засвар хийхэд түүх нь харагдах боломжтой болгосон.<br>• Тээврийн хэрэгслийн програмын ГУБ томилох зөвшөөрөх хэсэгт Тээврийн хэрэгслийн төрөл хэсэгт бүх тээврийн хэрэгслийн төрөл харагдах боломжтой болсон.<br>3. Гаалийн баталгаат бүсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, гаалийн хяналтын бүс тогтоолгох, тээвэрлэгч байгууллагад олгодог гаалийн итгэмжлэл авах, түр агуулах ажиллуулах хүсэлтийг хүлээн авч, хянаж, шийдвэрлэх зөвшөөрлийн цахим систем /license.mn/-г Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-с хөгжүүлэлт хийж</td><td></td><td></td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэвтрүүлсэн. Уг системийг ашиглахтай холбоотой өөрчлөлт, саналыг холбогдох/ХБГ, БАУХ/ хэлтэс, газраас УТҮГ-т гарган өөрчлөх боломжтой.<br>4. Татваргүй барааны дэлгүүрийн системийг холбох API функцийг хөгжүүлж, ЗҮГГ-ын цогцолборт байрлах 2 дэлгүүрт нэвтрүүлсэн.<br>5. Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа дэлгүүрүүдэд тавих хяналтыг сайжруулах ажлын хүрээнд дараах хөгжүүлэлтийг хийсэн.<br>- Чөлөөт бүсийн зорчигчийн мэдээллийг хилийн цэргийн системээс авах<br>- Зорчигчийн мэдээллийг гарах зөвшөөрөл олгож, хилийн цэрэгт мэдээлэл явуулах<br>- Зорчигчийн гарах хуудсыг цахимжуулсан<br>- Зорчигчийн орох мэдээлэл дээр хязгаарласан бараа бүтээгдэхүүний мэдээлэл харах<br>6. Ухаалаг гарц<br>• Санхүү, мэдээллийн технологийн газар УТҮГ-аас нэмэлтээр хөгжүүлэлт хийж тухайн ухаалаг гарц суурилуулсан ГХБ-д ажиллаж байгаа төхөөрөмжүүдийг ажиллаж байгаа эсэхийг шалгаж хянах боломжийг хөгжүүлж нэвтрүүлсэн.<br>• Хяналтын хаалга дээр ХШГУБ зөвшөөрсөн бол ГУАБ зөвшөөрөх үйлдлийг автоматаар хийх хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн.<br>• Хилийн биет шалгалт байцаагч хийх үйлдлийг ухаалаг гарц ашиглан автоматаар хийх боломжтой болсон.<br>• Ухаалаг гарцын хяналтын самбар дээр КАИС системээс өгч буй алдааны мэдээллийг харуулдаг болгох хөгжүүлэлтийг хийсэн.<br>• Ухаалаг гарц системд ХШГУБ болон ХШГУАБ нар КАИС системийн эрхээр нэвтрэх боломжтой болсон.<br>• Гашуунсухайт дахь гаалийн газрын харьяа “Смарт эко транс” гаалийн хяналтын бүсийн ухаалаг гарцын е-Тос системийг “КАИС” системтэй амжилттай холбосон.<br>• Замын-Үүд гаалийн газрын Зорчигч, ачаа тээврийн шалган нэвтрүүлэх цогцолбор, Шивээхүрэн ГГ, Гашуунсухайт боомтын ачаа тээврийн шалган нэвтрүүлэхэд ашиглаж байгаа ухаалаг гарцын тоног төхөөрөмжүүдэд системийн шинэ хувилбар суурилуулж, бүрэн тест хийж, тоног төхөөрөмжүүдийн шалгах талаарх сургалтыг байцаагч нарт оруулж, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гарын авлага бэлдэж, сургалтыг зохион байгуулж ажилласан. | | |
| 4 | Албан хаагчдын чадавхыг бэхжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд:<br>1.Гаалийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн асуудал хариуцсан албан хаагчдыг мэдээлийн технологийн чиглэлээр чадавхжуулах боломжийг хангаж ажилласан байна.<br><br>Сүүлийн хагас жилд:<br>1.Харьяа гаалийн газар, хороодын мэдээллийн технологийн ажил үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлага, зөвлөмжөөр тухай бүр хангаж, харьяа гаалийн газар, хороодын мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдад мэдээ, мэдээлэл олгох сургалтыг тогтмол зохион байгуулсан байна. | 1. Мэдээллийн технологийн асуудал хариуцсан албан хаагчдыг мэдээллийн технологийн чиглэлээр чадавхжуулах боломжийг хангах ажлын хүрээнд:<br>• 2024.08.15ны өдөр Novelsoft ХХК-иас Mulesoft програмын сургалтад хамрагдсан.<br>2. Зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын албан хаагчдад мэдээ, мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд:<br>• Харьяа гаалийн газар хороодын мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдад Гаалийн бүрдүүлэлтийн явцад Мэдээллийн технологитой холбоотой гарсан асуудлыг шийдвэрлэх, системүүдийн шинэчлэлтэй холбоотой мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Сургалтын сэдэв:<br>- КАИС системийн лабораторийн модуль<br>- Тээвэр<br>- Ухаалаг гарц<br>- Чингэлэг<br>- Сүлжээ, тоног төхөөрөмж<br>- Идок системд тоон гарын үсгээр баталгаажуулалт хийж, цахимаар албан бичиг солилцох<br>- Tableau програмыг ашиглан Гаалийн байгууллагын мэдээлэлд хэрхэн боловсруулалт, дүн шинжилгээ хийх дашбоард хөгжүүлсэн талаар<br>- Гаалийн системийн шинэчлэл, хиймэл оюун ухаан<br>• ШХГГ-т 2024.04.12-04.17-ны өдрийг дуустал дарга Б.Ганзориг, ГУАБ Н.Сандуйсүрэн, ГУБ Л.Доломжав нар ачаа тээврийн шалган нэвтрүүлэх цогцолборт ашиглаж байгаа ухаалаг гарцын системийн хэвийн ажиллагааг хангаж, нэвтрүүлж, сургалт зохион байгуулж ажилласан.<br>3. Гаалийн байгууллага болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт:<br>• ДГБ-с зохион байгуулсан “Дэвшилтэт технологи”-н Ази номхон далайн бүс нутгийн сургалтад ГУАБ Н.Мөнхзул, | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Н.Сандуйсүрэн нар 2024.09.23-2024.09.27-ны хооронд хамрагдсан. | | |
| 5 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Гаалийн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээгээр, Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд:<br>1.Бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, хуульд заасан хугацаанд багтаан тухай бүр дээд шатны байгууллагад тайланг хүргүүлж ажиллана.<br><br>Сүүлийн хагас жилд:<br>1.Бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, хуульд заасан хугацаанд багтаан тухай бүр дээд шатны байгууллагад тайланг хүргүүлж ажиллана. | МТГ-аас 2024 оны эхний хагас жил дараах тайланг холбогдох нэгжүүдэд хүргүүлэн ажилласан.<br>1. Тогтоол, шийдвэрийн биелэлтийг Хуулийн хэлтсээр дамжуулан Сангийн яаманд сар бүр хугацаанд нь хүргүүлсэн.<br>2. "Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 178 дугаар тогтоолын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөний 2024 оны 1-р улирлын биелэлтийг 2024.04.29-ны өдөр ХБГ-т;<br>3. Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг 2024.04.04-ны өдөр ЗУГ-т;<br>4. Алсын хараа 2050 өөрийн нэгжийн хамаарах ажлын тайланг 2024 оны 03 сарын 05-ны өдөр ЗУГ-т<br>5. Гаалийн ерөнхий газрын 2024 оны эхний хагас жилийн “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлтийн тайлангийн 3.1.10 дугаар заалтын биелэлтийг ЗУГ-т;<br>6. Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд холбогдох хуулийн хэрэгжилтийн хагас жилийн биелэлтийг Хуулийн хэлтэст;<br>7. Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг ДХАБХ-т;<br>8. Архивын төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг ЗУГ-т;<br>9. Гаалийн байгааллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний Эрчимжүүлэх төлөвлөгөөний биелэлт 2024.09.26-ны өдөр, 2024.11.28-ны өдөр ЗУГ-т хүргүүлсэн.<br>10. Төсвийн төлөвлөгөөний биелэлт 2024.09.20-нд хариуцсан нэгжид хүргүүлсэн.<br>11. Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын 178 дугаар тогтоолын хүрээнд хийсэн ажлын 2024 оны 3 дугаар улирлын биелэлт, хагас жилийн биелэлт, 1-р улирлын биелэлт тус бүр ХБГ-т хүргүүлсэн. | 01.01-11.30 | 100 |
| 6 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | | - | Сүүлийн хагас жилд:<br>1.Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгч (хандалт), цахим лавлагаа | 1. Гаалийн цахим үйлчилгээний систем (гааль.мн)-ээр лавлагаа авсан хэрэглэгийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад: | 01.01-11.30 | |

авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.
2.Хэрэглэгчдийн мэдээлэл авах хүсэлтийг цахимаар авдаг, хүргүүлдэг болсон байна.

| | 2023 | 2024 | Өссөн хувь |
|---|---|---|---|
| Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (ААН) | 379 | 434 | 14.5% |
| Гаалийн зөрчлийн лавлагаа (Иргэн) | 94 | 171 | 81.9% |
| Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа (ААН | 7360 | 8223 | 11.7% |
| Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (Иргэн) | 293 | 379 | 29.3% |
| Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа (Иргэн) | 1933 | 10674 | 452% |
| Гаалийн зөрчлийн лавлагаа (ААН) | 298 | 377 | 26.5% |

2. Хэрэглэгчдийн мэдээлэл авах хүсэлтийг цахимаар авах, хүргүүлэх ажлын хүрээнд:

| | 2023 | 2024 | Өссөн хувь |
|---|---|---|---|
| Авто тээвэр | 1463826 | 2405856 | 64.3% |
| Агаар | 6684 | 9319 | 39.4% |
| Төмөр зам | 20444 | 21181 | 3.6% |
| Импорт манифестын тоо | 147797 | 181415 | 22.7% |
| Транзит манифестын тоо | 190601 | 197078 | 3.3% |
| Дотоодын дамжин өнгөрүүлэх манифест | 79080 | 151761 | 91.9% |

| | | | |
|---|---|---|---|
| Экспорт, Импортын барааны гаалийн мэдүүлэг | 814080 | 952224 | 16.9% |
| Автомашины гаалийн мэдүүлэг | 102103 | 161513 | 58.1% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд:<br>Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэнэ.<br>Сүүлийн хагас жилд:<br>1.Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэн, түүнд дүн шинжилгээ хийж бууруулах арга хэмжээг авч ажиллана.<br>2.Бууруулсан эрсдэлийг санд бүртгэсэн талаар болон нэгжийн үйл ажиллагаанд учирсан ач холбогдол, үр дүнгийн талаар оновчтой тайлагнасан байна | Мэдээллийн технологийн (МТ) салбарт эрсдэлийг удирдах нь байгууллагын үйл ажиллагааны найдвартай байдал, өрсөлдөх чадварыг хадгалахад чухал үүрэгтэй. Гаалийн байгууллагын Мэдээллийн технологийн газрын эрсдэлийг тодорхойлох нь байгууллагын мэдээллийн системийн найдвартай байдал, аюулгүй ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах чухал үндэс суурь юм. Мэдээллийн технологийн эрсдэлд хамаарах хүчин зүйлс нь байгууллагын мэдээллийн систем, өгөгдөл, тоног төхөөрөмж, ажилтнууд болон гадаад орчны олон талт нөлөөнөөс шалтгаалж үүсэж боломжтой.<br>МТГ-с үйл ажиллагаа, чиг үүргийг нарийвчлан судалж, байгууллагын мэдээллийн технологийн чиглэлд гарч болзошгүй дараах эрдслийн хүчин зүйлсийг тодорхойлсон.<br>• Тоног төхөөрөмжийн эвдрэл<br>• Сүлжээ, системийн тасалдал<br>• Програм хангамжийн алд аа<br>• Кибер халдлага<br>• Мэдээллийн алдагдал<br>• Мэргэшсэн ажилтны дутагдал<br>• Сургалт, хөгжлийн дутагдал<br>• Хүний нөөцийн тогтворгүй байдал<br>• Байгалийн гамшиг<br>• Төсвийн дутагдал<br>Үнэлгээний аргачлал нь эрсдэл бүрийг магадлал (тохиолдох боломж) болон нөлөөллийн (тохиолдсон тохиолдолд үзүүлэх нөлөө) түвшинг тодорхойлж, эрсдэлийн матрицад байршуулсан. Эрсдэлийн матрицад байршуулсанаас харахад өндөр, дунд, бага эрсдэлд дараах хүчин зүйлс орсон бөгөөд эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө гаргасан.<br>Тоног төхөөрөмжийн эвдрэл, сүлжээ тасалдал, төсвийн дутагдал зэрэг эрсдэлүүд байгууллагын үйл ажиллагаанд ноцтой нөлөө үзүүлэх тул яаралтай хяналт, шийдэл шаардлагатай. Технологийн шинэчлэл, мэргэшсэн ажилтны дутагдал зэрэг асуудлууд нь үйл ажиллагаанд зарим саад учруулж болох ч урт хугацаанд илүү том асуудал болж хувирах магадлалтай. Байгалийн гамшиг нь ховор тохиолддог ч тохиолдсон үед их хэмжээний нөлөө үзүүлдэг тул нөөц төлөвлөгөө шаардлагатай. | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд:<br>1.Захиргааны зөвлөлийн хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Онлайн, Шуурхайгаас болон бусад хэлбэрээр удирдлагаас өгөгдсөн нийт үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж, тухай бүр тайлагнасан байна.<br>Сүүлийн хагас жилд:<br>1.Захиргааны зөвлөлийн хуралдаан Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Онлайн, Шуурхайгаас болон бусад хэлбэрээр удирдлагаас өгөгдсөн нийт үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж, тухай бүр тайлагнасан байна. | Захиргааны зөвлөлийн хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Онлайн, Шуурхайгаас болон бусад хэлбэрээр удирдлагаас өгөгдсөн 16 үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж, тухай бүр ЗДАС-ийн Үүрэг даалгаврын программд оруулсан. Үүрэг даалгаврын төрлөөр нь ангилвал:<br>- Үүрэг даалгавар 11<br>- Зөвлөмж 2<br>- Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан 1<br>- Онлайн хурлын даалгавар 1<br>- Ёс зүйн дэд хорооны хуралдаан 1 | 01.01-11.30 | 100 |
| 9 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулж, цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид тогтмол бүртгүүлж, гадуур ажилласан, өвчтэй, чөлөөтэй тохиолдол бүрт | Тайлант хугацаанд ажлын өдрийн өглөө, орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид цагаа бүртгүүлж, нийт 5 хүсэлтийг тус тус Захиргаа дотоод ажлын системд тухай бүрт илгээж, хянуулсан.<br>• Томилолтоор ажиллах 1;<br>• Хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 2;<br>• Бусад 2; | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | СЕРП программаар тухай бүр илгээж ажиллсан байна. | | | |
| 10 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Стратеги 1.4.35.Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх/ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | - | Алтанбулаг боомт, Бичиг боомт, Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын ажил дуусаагүй учир тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдээгүй хүлээгдэж байна. | 01.01-11.30 | 100 |
| 11 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.29. IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдын нэгдсэн холбоо (НАРТАМ) -той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох/ | Хэрэгжилт,гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд:<br>1.ОУАТХ-ны програм хангамжийн багтай цахимаар холбогдож ажиллана.<br><br>Сүүлийн хагас жилд:<br>1.IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо (НАРТАМ) -тай хамтран<br>2.TIREPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох программыг турших, нэвтрүүлнэ. | 1. Олон улсын автотээвэрчдийн холбооноос “Международный центр приграничного сотрудничесва”-д 2024 оны 5 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан уулзалт, хэлэлцүүлэгт ГУАБ Н.Сандуйсүрэн оролцсон. Уулзалтаар:<br>• TIR горимын тээвэрлэлтийг хөнгөвчлөх механизм;<br>• TIR горимын тээвэрлэлтийг “Ногоон гарц”-аар нэвтрүүлж байгаа туршлага;<br>• БНХАУ-ын гаалийн байгууллагаас ТИР горимын тээвэрлэлтэд тавьж буй хяналттай холбоотойгоор бусад улс орнуудын тээвэрлэлтэд тулгарч байгаа бэрхшээл зэрэг асуудлаар ярилцсан.<br>2. Олон улсын автотээвэрчдийн холбоо /IRU/-оос ТИР-ын урьдчилсан цахим мэдээ /TIR-EPD/-г CAIS системтэй холбох ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>• 4-р сарын 8-нд IRU-н систем болон CAIS системийн хооронд мэдээлэл солилцоход ашиглагдах сервисүүдийн тестийн орчинг зохион байгуулах ажлыг эхлүүлсэн. Тестийн орчинг зохион байгуулах явцад сервис дээрх сертификатийн файл дээр алдаа гарч, мэдээлэл солилцох боломжгүй байсныг 4-р сарын 29-нд шийдвэрлэж хэвийн ажиллагаанд оруулсан. Энэ хугацаанд IRU-гаас илгээх EPD мэдүүлгийг хүлээн авч, | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүлээн авсан эсэх хариуг буцааж илгээх сервисийн хөгжүүлэлтийг хийж бэлэн болгосон.<br>• 5-р сарын 3-нд IRU талаас тестийн 6 EPD015 /EPD мэдүүлэг/ (экспорт – 2, транзит – 2, импорт - 2) илгээснийг амжилттай хүлээн авч, хариу мэдээлэл болох EPD928 /Хүлээн авсан баримт/ -ыг илгээж IRU талд мөн амжилттай хүлээн авсан.<br>• 5-р сарын 9-нд хүлээж авсан 6 EPD-ийг монголын гаалиас хүлээн зөвшөөрсөн гэх мэдээлэл болох EPD028 /Гаалийн лавлагаа/-ыг IRU руу амжилттай илгээсэн. Үүний дараагаар 5-р сарын 21-нд тус 6 EPD-ын дамжин өнгөрөх зөвшөөрлийн мэдээлэл болох EPD029 /Дамжин өнгөрөх зөвшөөрөл/-ыг илгээсэн.<br>• 5-р сарын 30-нд экспорт болон транзитын 4 EPD-ын хувьд WSST Exit notification буюу Гарах мэдүүлэг, импортын 2 EPD-ын хувьд WSST Final unloading буюу Ачих мэдүүлгийн 6 мэдээллийг илгээж IRU амжилттай хүлээн авсан.<br>• 6-р сарын 6-нд тус 6 EPD мэдүүлгийн хилээр гаргах мэдээлэл болох EPD045 /Хилээр гаргах/ мессежийг амжилттай илгээсэн.<br>• EPD917 - Автомат техникийн татгалзал, EPD016 – EPD татгалзах, EPD014 – Цуцлах хүсэлт, EPD009 – Цуцлах шийдвэр, EPD051 – Дамжин өнгөрөхийг зөвшөөрөөгүй, EPD025 – Лац, ломбо шинэчлэх, EPD140 – Хүлээн аваагүй тээврийн хүсэлт, EPD141 – Хүлээн аваагүй тээврийн мэдээлэл гэсэн мессежүүдийг сервисээр дамжуулан илгээх болон хүлээн авахад бэлэн болгох ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>• Гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг уялдуулж, холбох ажлыг 2024 оны 11-р сарын 08-ны өдөр дуусгаж, нэвтрүүлэх зорилгоор дараах газруудад албан томилолтоор очиж ажилласан.<br>- Замын-Үүд дэх гаалийн газарт МТГ-ын дарга Б.Ганзориг, ГУАБ Н.Сандуйсүрэн, ГУБ М.Оргил, ХБГ-ын ГУБ Э.Одбаяр нар 2024.11.10-ны өдөөс 2024.11.15-ны өдрийг дуустал; | | |
| 12 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.27 Цахим | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эхний хагас жилд:<br>1.Системийн хэмжээнд удирдлагууд, хяналт, шалгалт хийж буй гаалийн | 1. Системийн хэмжээнд удирдлагууд, хяналт, шалгалт хийж буй гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгож тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх/ | | | улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгож тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх үйлдлүүд болон гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна.<br>Сүүлийн хагас жилд:<br>1.Төрийн болон төрийн бус байгууллагатай харилцахдаа тоон гарын үсгийг ашиглаж эхэлсэн байна | үйлдлүүд болон гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашиглах ажлын хүрээнд:<br>• Гаалийн ерөнхий дэргэдэх бүрдүүлэлтийн цахим төвийн дарга болон ахлах байцаагч, байцаагч нарын нийт 47ш тоон гарын үсгийн хугацааг сунгаж шаралт хийж cais системтэй холбосон бөгөөд мөн ЗҮГГ-ын дарга ахлах байцаагч нарын 121ш тоон гарын үсгийн 1жилийн сунгалтыг тус гаалийн газарт томилолтоор ажиллан газар дээр шарж cais системтэй холбон хүлээлгэн өгсөн байгаа. УБГГ-ын 140ш дарга ахлах байцаагч нарын тоон гарын үсгийн шарах ажил хийгдэж байна. Мөн Газар хороодын дарга нарын 14ш тоон гарын үсгийг шарж бэлэн болгосон тараах ажлыг хийж байна.<br>• Гаалийн ерөнхий газрын дарга болон хэлтсийн дарга нарт тоон гарын үсгийн гэрчилгээ суулгаж авсан бөгөөд гаалийн үндсэн систем болох CAIS системтэй холбож, хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>• Замын-үүд дэх гаалийн газар, ЧХОУНБГГ, Сэлэнгэ аймаг дах гаалийн газар, УХШИГГ, ГЕГ-ын дэргэдэх БДШ газрын Дарга, албаны дарга,ГУАБ, ГУБ нарт тоон гарын үсгийн гэрчилгээг 1 жилийн хугацаатай суулгаж хүлээлгэн өгсөн бөгөөд КАИС, СЕПС, СИМС систем рүү нэвтрэн хяналт шалгалтанд ашигладаг болсон. Нийт 540 тоон гарын үсгийн төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.<br>• Дорноговь аймгийн Замын-Үүд боомтын зорчигч тээврийн шалган нэвтрүүлэх цогцолборт ашиглаж байгаа ухаалаг гарцын системийн хэвийн ажиллагааг хангуулах, тоон гарын үсгийг нэвтрүүлэх, сургалт зохион байгуулахаар 2024.03.21-03.25-ны өдрийг дуустал 5 хоногийн хугацаанд дарга Б.Ганзориг, ГУАБ Н.Сандуйсүрэн, ГУБ Л.Доломжав, П.Хорлоо нар томилолтоор ажилласан.<br>• Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын албан хаагчдын тоон гарын үсгийг нэвтрүүлэх, чөлөөт бүсийн зорчигчийн бараа бүртгэлийн бар код хэвлэгчийг шалгах програмын түвшний тест хийх, сүлжээний тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангахаар ГУБ П.Хорлоо, М.Оргил нар 2024.03.05-03.07-ны өдрийг хүртэл 4 хоногийн хугацаанд томилолтоор ажилласан.<br>• УБГГ-ын 140ш тоон гарын үсгийн материалыг хүлээн авч нягтлах ажил хийгдэж дууссан бөгөөд шаралтын ажил хийгдэж байна 2024.12.25ны өдөөс кайс, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | системтэй холболтыг хийж хэрэглээнд ашиглана.ГСГГ,ШХГГ-ын материалыг бүрдүүлэх ажил хийгдэж байна.<br>• БДШГ-ын дарга болон ахлах,байцаагч нарын нийт 23 тоон гарын үсгийг шарж хүлээлгэн өгсөн бөгөөд алба хаагчдад цахим санд зөвхөн өөрийн эрхээр орж ажиллах бусад мэдээллийг нууцлалын түвшинд хадгалах хамгаалах, албан хэрэгцээнд ашиглаж байна.<br>• Төрийн болон төрийн бус хувийн хэвшил ХХК байгууллагатай албан бичиг цахимаар солилцох ажлын хүрээнд DOCх дундын системтэй архив бичиг хэргийн систем болох ИДок систем гаалийн ерөнхий газар болох харьяа гаалийн 19 газар хороод бүрэн холбогдсон ба тус дундын системээр дамжуулан төрийн болон төрийн бус хувийн 4000 гаруй байгууллагуудтай тоон гарын үсэг ашиглан тоон гарын үсгээрээ баталгаажуулалт хийж цахимаар албан бичиг солилцохыг бүрэн нэвтрүүлсэн. | | |
| 13 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Архивын төлөвлөгөө-Байгууллагын архив, бичиг хэргийг цахимжуулах/ | Үйл ажиллагаа | - | Сүүлийн хагас жилд:<br>1.Архивын лавлагаа /Гаалийн мэдүүлгээс бусад/ 100 хувь цахимжуулсан байна.<br>2.Гаалийн ерөнхий газар болон харьяа гаалийн газар, хороод хоорондын албан бичиг хүлээн авах, хүргүүлэх ажил бүрэн хийгдсэн, 100 хувь цахимжсан байна. | 1. Архивын лавлагааг цахимжуулах ажлын хүрээнд 19 гаалийн газар хороо болон гаалийн ерөнхий газарт ирсэн, явсан албан бичиг нь цахим бичиг хэрэг хөтлөлтийн иДок системээр дамжиж байгаа тул бүрэн цахим архивд орсон. Мөн 2004-2018 оны гаалийн ерөнхий газрын А,Б тушаалын баримтуудыг Идок, архивын систем дээр цахимжуулах ажил 90%-тай хийгдсэн. Иймд дээрхи баримтуудын архивын лавлагааг тоон гарын үсгээр баталгаажуулан Идок системээр олгох боломжтой.<br>2. Цахим бичиг хэрэг хөтлөлтийн Идок системээр албан бичгийг 100% цахимаар илгээх, хүлээн авах програмын даалгаврыг гүйцэтгэгч компанид захиалга өгсөн. Програмын хөгжүүлэлт дууссаны дараа 2024.05.06, 2024.07.29 -ны өдөр туршилт хийж, програмын түвшинд гарсан алдааг Нью соник ХХК-д хандан засуулсан. Сүүлийн туршилтыг 2024.12.03-ны өдөр хийхэд алдаа гараагүй, Б.Ганзориг даргын гарын үсгээр 3 албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан, цахимаар явуулсан.<br><br>Цахим бичиг хэрэг хөтлөлтийн Идок системээр тоон гарын үсгээр баталгаажуулсан албан бичиг цахимаар явуулах бүрэн боломжтой болсон.<br><br>Ерөнхий газрын дарга нар тоон гарын үсгийн төхөөрмжийг авсан, харья газар хороодын дарга нарт тоон гарын үсгийн | 01.01-11.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төхөөрөмж бэлэн болсон тараах өгөх ажил хүлээгдэж байгаа. | | |
| 12 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.35.Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ./ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, солилцох мэдээллийг тохирсон байна.<br>2. Ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг ижилсгэсэн байна. | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хилийн удирдлагын нэгдсэн систем ХУН” төслийн хүрээнд ХХЕГ, ГЕГ-н мэдээллийн нэгтгэх ажил хийгдэж байна. Уг ажлын хүрээнд:<br>• Хилээр орох чиглэл эхэлж ХХЕГ-т тээврийн хэрэгслийн орох бүртгэлийн бүртгэж, цахимаар гаалийн байгууллагад илгээнэ.<br>• Хилээр гарах чиглэлд эхэлж Гаалийн байгууллага тээврийн гарах бүртгэлийг КАИС системд бүртгэж, ХХЕГ-руу цахимаар илгээнэ. Үүний дараа ХХЕГ-с тухайн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигчийн мэдээллийг бүртгэж, гаалийн байгууллагад илгээнэ.<br>• “ХУН” системийн холболтын модуль ашиглан чөлөөт бүсийн дэлгүүр, үйлдвэрийн газар нэг талаас нөгөө талаас Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Замын-Үүд Чөлөөт бүсийн захирагчийн алба нэг цогц болж үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зорилгоор Гаалийн автоматжуулсан мэдээллийн системд (КАИС) нэмэлт өөрчлөлт оруулах, Хилийн удирдлагын нэгдсэн тогтолцоонд холбох програмын хөгжүүлэлтийг гүйцэтгэж, туршилтаар нэвтрүүлэхээр 2024.11.11-2024.11.14-ны хооронд Замын-Үүд дэх Чөлөөт бүсэд ГЕГ, ХХЕГ, Гэрэгэ системс ХХК, Аствишн ХХК гэсэн 4 байгууллагын ажлын хэсэг томилогдон ажилласан. | 01.01-11.30 | 100 |
| 13 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.35. Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар | | | 1.Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх бодлогын даалгавар боловсруулж, Мэдээллийн технологийн төвд хүргүүлнэ. | • Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшний хөгжүүлэлтийг И-Монгол академи УТҮГ-аар хийлгэхээр болсон. Тус асуудлаар 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж ажилласан.<br>• Хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийг иргэд, ААН-үүд гааль.мн системд 72 цагийн өмнө бүртгүүлэн, КАИС системд илгээснээр уг тээврийн хэрэгсэл хил дээр ирэхэд байцаагч баталгаажуулалт өгөх хилээр нэвтрэх боломжтой болгон системийн хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн. Гааль.мн-ы тээврийн хэрэгслийн бүртгэлийг ашиглан нийт 1,005,224 тээврийн хэрэгсэл бүртгүүлсэн байна. | 01.01-11.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх/ | | | 2.Мобайл аппликейшн туршилтаар ашигласан байна. | | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Гаалийн байгууллагаас болон бусад байгууллагаас зохион байгуулсан богино, дунд хугацааны сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор | - | Гаалийн байгууллагаас болон бусад байгууллагаас зохион байгуулсан богино, дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | Гаалийн ерөнхий газраас 7 хоног бүрийн 5 дахь өдөр зохион байгуулдаг Мэдээллийн цагт хамрагдсан. | 01.01-11.30 | 100 |
| 2 | 1234.мн сайтаас онлайнаар мэдээллийн технологийн хичээл худалдаж авч сурах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1234.мн сайтаас онлайнаар мэдээллийн технологийн хичээл худалдаж авч суралцсан байна. | 1234.мн сайтаас онлайнаар мэдээллийн технологийн хичээл худалдаж авч суралцсан. | 01.01-11.30 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ........................ /Н.САНДУЙСҮРЭН/ 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Н.САНДУЙСҮРЭНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Мэдээллийн технологийн газар

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| Зорилт 1.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | |
| 1. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.1.26.Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох/ | 60 | 8 | 68 | |
| 2. | Мэдээллийн нэгдсэн санд дүн шинжилгээ хийж, өгөгдлийг боловсруулсан байдал | 58 | 8 | 66 | |
| 3. | Программ хангамжуудыг шинээр боловсруулах, хөгжүүлсэн байдал | 55 | 8 | 63 | |
| 4. | Албан хаагчдын чадавхыг бэхжүүлсэн байдал | 55 | 10 | 65 | |
| 5. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| 6. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 60 | 9 | 69 | |
| 7. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 56 | 8 | 64 | |
| 8. | Үүрэг даалгаврын биелэлт | 60 | 9 | 69 | |
| 9. | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |
| 10. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Стратеги 1.4.35.Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг | 55 | 8 | 63 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | өргөтгөн шинэчлэх/ | | | | |
| 11. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.29. IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдын нэгдсэн холбоо (НАРТАМ) -той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох/ | 55 | 8 | 63 | |
| 12. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.27 Цахим гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх/ | 55 | 8 | 63 | |
| 13. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Архивын төлөвлөгөө- Байгууллагын архив, бичиг хэргийг цахимжуулах/ | 59 | 9 | 68 | |
| 14. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.35.Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ./ | 58 | 8 | 66 | |
| 15. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.35. Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх/ | 58 | 8 | 66 | |

## 2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Гаалийн байгууллагаас болон бусад байгууллагаас | 80 | 12 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зохион байгуулсан богино, дунд хугацааны сургалтад хамрагдах | | | |
| 2. | 1234.мн сайтаас онлайнаар мэдээллийн технологийн хичээл худалдаж авч сурах | 100 | 15 | |
| **Дундаж оноо:** | | | 13.5 | |

## 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 3. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| **Дундаж оноо:** | | **7** | |

## 4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 7 |
| 3. | Харилцаа | 7 |
| **Дундаж оноо: 7.3** | | |

## 5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | *66.2* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *13.5* |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | *7* |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *7.3* |

| | | |
|---|---|---|
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **94** |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга***
Мэдээллийн технологийн газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ (Б.Ганзориг)

2024.12.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
***зөвшөөрсөн:***
Гаалийн улсын ахлах байцаагч ................................ (Н.Сандуйсүрэн)

2024. 12. 10 (огноо)

***Үнэлгээг хянасан:***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч ................................ (Г.Энхтайван)

XII/20, 2024 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч
................................ (Ө.Тэгшээ)

2024. 12. 20 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч***
Гаалийн ерөнхий газрын дарга ................................ (Р.Отгонжаргал)

................................(огноо)